

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 22 оны 12 сарын 22 -ны өдөр

№ 22/06

Улаанбаатар хот

Аудитын байгууллага сонгох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компани нь “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийг компанийн 2022 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргах байгууллагаар сонгосугай.
2. Энэхүү тогтоолын дагуу “Шонхор үнэлгээ аудит” ХХК-тай холбогдох гэрээ байгуулах, гарын үсэг зурах, гэрээний үнийг тогтоох бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 22-ны өдөр

№ 22/07

Улаанбаатар хот

Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь хэсгүүд, 41 дүгээр зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.23 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь нийт 10'000'000'000.0 (арван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг (цаашид “Бонд” гэх) Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан 2023 оны 1 дүгээр улиралд багтаан олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалахаар гаргасугай.

2. Бондын нөхцөлийг дор дурдсанаар баталсугай.

Бондын арилжаа	Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд
Бондын төрөл	Энгийн хүүтэй бонд
Бондын нийт үнийн дүн	10'000'000'000.0 /Арван тэрбум/ төгрөг
Нэгж бондын нэрлэсэн үнэ	100'000.0 /Нэг зуун мянга/ төгрөг
Бондын нийт тоо, ширхэг	100'000.0 /Нэг зуун мянга/ ширхэг
Бондын хугацаа	18 сар
Бондын жилийн хүүгийн түвшин	19.2 /Арван ес аравны хоёр/ хувь
Хүү төлөгдөх давтамж	Улирал тутам
Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах Бонд эзэмшигчийн эрх	Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 дахь сараас хойш Бондыг үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах эрхтэй
Бондын барьцаа	Толгой компани нь өөрийн эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцааг холбогдох журмын дагуу барьцаалуулна
Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт	Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ
Бондын хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

3. Энэхүү тогтоолын дагуу нээлтэй хүрээнд Бонд гаргахтай холбоотойгоор “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийг Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх байгууллагаар, “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-ийг Үндсэн Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх байгууллагаар, “Голомт Капитал ҮЦК” ХХК, “Райнос инвестмент ҮЦК” ХХК-ийг Туслах Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх байгууллагаар, “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийг аудитын дүгнэлт гаргах байгууллагаар тус тус сонгосугай.

4. Энэхүү тогтоолын дагуу Бондыг олон нийтэд санал болгож, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай гэрээ байгуулах, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

